

4 Эрүүл орчинд амьдрах эрх ба шударга ёс

Энэ бүлэгт

	Хуудас
Вопал хотод тохиолдсон аюул гамшиг.....	42
Хүний эрх, шударга ёсны төлөөх тэмцэл.....	43
Аюул гамшиг яагаад гарав.....	46
Орчин тойрныг хамгаалах зориулалттай эрүүл мэндийн клиник.....	46
Өөрчлөлтийн төлөө ажиллах нь.....	48
Боломжийн эрсдэл гэв үү? Хэний хувьд?.....	49

Эрүүл орчинд амьдрах эрх ба шударга ёс



Орон нутгийн хүн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Харамсалтай нь, энэхүү эрхийг тэр бүр хангалттай эдэлж чаддаггүй юм. Ихэнх хүмүүс наад захын хэрэгцээний зүйлсийн хомсдолтой, хортой бодисын илүүдэлтэй орчинд амьдарч байна. Ялангуяа арьс өнгө, яс үндэс, шашин, хүйс, нийгмийн анги давхрага, ядуурал болон бусад шалтгаанаас болж нийгмийнхээ доод давхрагад байгаа хүмүүсийн хувьд энэ эрх нь байнга зөрчигдөж байна. Яагаад гэвэл энэ хүмүүс хамгийн түрүүнд хордож, мөн хамгийн ихээр бохирдож байна.

Эрүүл орчинд амьдрах эрх нь зөрчигдсөн хүмүүс эрүүл аюулгүй орчинд амьдрахын тулд орчны эрүүл ахуйн шударга ёсны төлөө тэмцэл өрнүүлдэг. Дэлхий дээр орчны эрүүл ахуйн гамшигаас үүдэн шударга бусаар зовж шаналсан олон иргэд, нөхөрлөлүүд зохион байгуулалтад орж, эрүүл мэндийн эрхээ хамгаалах шударга ёсны төлөөх тэмцэлд нэгдсэн түүх олон байдаг. Энэ бүлэгтээ бид тэдгээр хүмүүсийн заримынх нь тухай өгүүлэх болно.

Вопал хотод тохиолдсон аюул гамшиг

1984 оны 12 сарын 3-ны шөнө Энэтхэгийн Вопал хотод аймшигт гамшиг тохиолджээ. Вопал хотын ядуучууд амьдардаг хорооллын ойролцоо байрлах бордооны үйлдвэр агаарт олон тонн хорт хий алджээ. Үйлдвэрийн дохиоллын систем нь унтраастай байсан учир хорооллынхон ямар ч аваарын дохио сонссонгүй. Хорт хийн аюулаас амьд үлдсэн Аззиза Султан ингэж ярих.

Би хүүхдээ муухай ханиалгах дуунаар тэр шөнө сэрсэн юм. Өрөө маань тэр чигээрээ цагаан цэцэгд хүчигдсэн байлаа. Би хүүхдүүдийг гүйгээрэй гүйгээрэй гэж хамгаалахыг сонсов. Тэгтэл би ч бас муухай ханиалаж эхэлсэн. Амьсгалах бүртээ би гал залиж байгаа юм шиг байлаа.



Бас нэгэн амьд үлдсэн гэрч Чампа Деви Шукла ингэж дурсаж байна.

Хүүхдүүс босцгоогоод юу л амсаж байна тэрэнтийгээ гүйгээсэн. Зарим нь бифр хувцасгүй гүйж байсан. Тэд амьд үлдэхийн тулд учир зүүгүй гүйж байлаа.




Миний биеэр дүүрэн улаан перц цацчихсан мэт гашуу оргиж байсан. Нүүднээс маань нулимс гарч, хамраас ус гоожин аман дотор маань ховс дүүрч байв.

Хорт хий тэр шөнө маш олон хүний амийг авч одсон юм. Гурав хоногийн дотор 8000 хүн нас баржээ. Гэвч энэ бол аюулын дөнгөж эхлэл нь байлаа. Түүнээс хойш 20 жил болоход биед нь үлдсэн хорт хийнээс болж 20.000 хүн хордлогоор нас баржээ. Амьд үлдсэн хүмүүс амьсгалын өвчин, байнгын ханиад, халуурал, гар хөл сулрах, бие сулрах, айдас стрессэд орох, хорт хавдар тусах зэргээр өвчилсөн юм. Амьд үлдсэн хүмүүсээс төрсөн хүүхдүүд төрөлхийн хүнд гажигтай төрцгөөсөн. Тэр хүүхдүүд доголлон, өсөлт багатай, үргүй, бэлэг эрхтэний гажигтай, мэдрэлийн системийн гажигтай төрцгөөсөн. Ганцхан шөнө гарсан Вопалын хорт хийн хохирогч нарын тоо нийтдээ 150.000 болсон юм.

Хүний эрх шударга ёсны төлөөх тэмцэл

Өнөөдрийг болтол хорт хий асгарсан газруудын хавиар цэвэрлэгээ хийгдээгүй, хорт хий асгарсан үйлдвэр дампууран аюулт тэр өдрийг сануулан дүнхийж үлджээ. Химийн хорт бодис одоо ч ил цацагдаж байгаа бөгөөд хотын доорх гүний ус хордсон байна. Олон хүмүүс эмнэлгийн тусламж авч чадаагүй бөгөөд эрүүл мэндээ тогтмол үзүүлэх газаргүй хэвээр байна. Ийм учраас Вопалын оршин суугчид химийн аюулыг болоод өнгөрсөн зүйл төдий гэж үзэхгүй байна. Тиймээс тэд химийн аюулыг өдөр тутам тулгарч буй асуудал гэж үзлээ. Бордооны үйлдвэр нь үндэстэн дамжсан корпорацийн өмч байсан бөгөөд “Юнион карбид” гэдэг байв. Хорт хийн гамшигт өртсөн хүмүүс өөрсдийнх нь эрх зөрчигдсэн гэдгийг мэдэж байлаа. Хордсон хүмүүс өвчтэй нэгнийгээ сахиж, ажилгүй гэртээ суух, явах чадалгүйгээс эмнэлэгт очиж чадахгүйд хүрч үргэлжлүүлэн хохирч байлаа. Тэд компанийг хариуцлагаа хүлээ гэж шаардав. Гэвч “Юнион карбид”-ийнхан алдаа гаргасан ганц ажилчны хариуцлага байсан учраас компани хариуцлага хүлээхгүй гэж хэлжээ. Вопалынхан өөрсдийгөө хамгийн их хохирсон төдийгүй ядуу байсан учраас орчин тойронд нь аюултай зүйл барьж байгуулагджээ гэж үзэн өөрсдийнхөө эрх, шударга ёсны төлөө тэмцэж эхлэв.




Аюул гамшиг яагаад гарав

Вопалын осол бол дахин давтагдаж болохгүй аймшигтай аюул байсан юм. Хэдийгээр энэ аймшигтай зүйл гэнэт тохиолдсон боловч бас тийм ч гайхаад байх зүйл биш байлаа. Учир нь “Гэвч яагаад” хэмээх хэлэлцүүлгийн үеэр хүмүүс Вопалын аюулын учир шалтгааныг ойлгож эхэллээ.




Дэлхий даяар том корпорациуд хортой үйлдвэрийн газар, хортой хаягдал, бусад аюултай хаягдлын төслүүдээ хамгийн хүчин мөхөс, ядуу зүдүү, өөрийгөө хамгаалах чадваргүй хүмүүсийн дунд байгуулдаг. Ийм замаар ядуу орнууд, ядуу амьдралтай орон нутгийнхан хамгийн аюултай үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, хамгийн аюултай бохирдол, хог хаягдлын газар нутаг болдог юм. Ийм ч учраас орчныхоо эрүүл мэндийг хамгаална гэдэг нь зөвхөн хэрэглэж байгаа бүтээгдэхүүнээ өөрчилж, хаяж байгаа хог хаягдлаа ялгах төдийнхөөр бус бас эрх мэдэлтнүүд эрхээ яаж ашиглаж байна, хэний гэр орны ойролцоо эрүүл мэндэд аюултай ямар зүйлийг байрлуулах шийдвэр гаргаж байна гэдгийг хянах ёстой юм.



Вопалд шударга ёс тогтоохын төлөөх олон улсын тэмцэл

Вопалын хорт хийн аюулаас амьд үлдсэн хохирогчид өөрсдийнхөө асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, компанитай хариуцлага тооцуулахын тулд хамтран тэмцэж эхэллээ. Тэд өлсгөлөн зохион байгуулж, өөрсдийнхөө дуу хоолойг сонстол нь юу ч идэхгүй татгалзаж чадлаа. Тэд Вопал хотоос 750 км хол орших нийслэл хот руугаа ямар ч хоол идэхгүй, ус уухгүйгээр аялав. Тэд нийслэл хотын гудамжаар шударга ёсыг шаардаж жагслаа. Тэд засгийн газрынхаа байгууллагуудын урд майхан босгон суулт тэмцэл хийв. Тэд 3 сарын турш тэндээ байрлалаа.



Өдөр бүр үүрийн гэгээнээс үдэш болтол тэд шаардлагаа уншиж байв. Осол болсноос хэдэн жилийн дараа шүүхийн шийдвэр гарч, “Юнион карбид” компаниас Энэтхэгийн засгийн газарт 470 сая доллар төлүүлэхээр болов. Энэ бол чухал ялалт байсан боловч хангалттай ялалт болж чадаагүй юм. Хохирол төлсөн мөнгөний ихэнх хэсэг нь амьд үлдэгсдэд хүрч чадаагүй юм.

Удсан ч үгүй “Юнион карбид”-ыг “Доу кемикал” хэмээх үндэстэн дамжсан корпораци худалдан авав. “Доу кемикал” нь өвчинд нэрвэгдсэн хүмүүсийн эмнэлгийн зардлыг төлөхөөс бас л татгалзав. Осол болсон газар болох Энэтхэгийн засгийн газар ч, компанийг бүртгэсэн газар болох АНУ ч компанийн удирдах зөвлөлийг шүүхэд шилжүүлэх талаар арга хэмжээ авсангүй.

Ослоос амьд үлдсэн хохирогчид шударга ёсыг тогтоох хөдөлгөөнөө үргэлжлүүлэв. Тэд оюутны байгууллага, байгаль орчны байгууллага болон хүний эрхийн байгууллагаас дэмжлэг авлаа. Дэлхийн өнцөг буланд байсан хүмүүсийн тусламжтайгаар Вопалын хохирогчид өөрсдийн гомдлыг “Юнион карбид” болон “Доу кемикал” компанийн удирдлагад хүргүүлж чадлаа. Тэднийг дэмжиж бусад хүмүүс ч өлсгөлөн зарлав. Энэ бүх үйл явцын туршид тэднийг ар гэрийнхэн нь дэмжиж, хорт хийний хохирогчдын талд бат зогссон юм.

Вопалд шударга ёс тогтоохын төлөөх кампанит ажлын гол уриа нь “Вопал хэзээ ч давтагдах ёсгүй” гэсэн уриа байлаа. Энэ кампанит ажлын гол зорилго нь ижил төстэй байгаль орчны гамшигийг дахин гаргуулахгүй гэсэн зорилго байв. Өөрсдийн тэмцлийг олон улсын хэмжээнд хүргэж чадсанаараа тэд дэлхийн өнцөг буланд байгаа хүмүүст хорт хийн үр дагаврын тухай зааж сургасан юм. Вопалын хохирогчид үйлдвэрлэлийн осол хэзээ ч гарч болзошгүй гэдгийг хүмүүст харуулж, үйлдвэрлэлийн осолд ядуу хүмүүс хамгийн их өртдөг гэдгийг анхаарлын төвд оруулж өгсөн юм. Тэдний тэмцлийн жишээ орон нутгийн оршин суугчдын бусад тэмцлүүдэд үлгэр дуурайл, загвар нь болжээ.

Хорт бодис хүний биед ямар замаар ордог вэ?



Идэх, уух
/шингээх/



Амьсгалах
/уушигаар/



Арьсаар нэвчиж
/нэвчих замаар/

Хүн хортой химийн бодисын орчинд удаан хугацаагаар байх тусам илүү их хордлого авч хохирно. Водяной хувьд гэвэл, тэнд байсан олон мянган хүн хорт хийг уушигаар амьсгалж, арьсаараа нэвчүүлэн хорджээ. Энэ бол нэг удаагийн шууд хордлого байлаа. Дараа нь химийн бодисуудыг үйлдвэрлэлийн орчноос зайлуулж цэвэрлэхгүйгээр орчин тойронд нь тарааж газрын хөрс, гүний усанд нэвчүүлжээ. Тиймээс нэг удаагийн хордлогоос хойш олон жил болсон ч гэсэн хүмүүс ууж байгаа усаараа хорыг авч хордсоор байна. Энэ бол удаан үргэлжлэх хордлого юм.

Водяной мэтийн том хэмжээний химийн хордлого гарах юм уу, эсвэл хортой будаг уусмал жирийн бүтээгдэхүүн зэрэг жижиг зүйлээс гарч буй химийн хор илэрвэл хамгийн түрүүнд тухайн химийн бодисын тархалтыг зогсоохын тулд өөрөөсөө холдуулах хэрэгтэй. Ингэсний дараа цаашдын хор алдагдахаас урьдчилан сэргийлэх талаар ажиллах хэрэгтэй. /Химийн хорт бодисын учруулах аюулын талаар 16-р бүлгээс үзнэ үү/

Орчин тойрныг хамгаалах зориулалттай эрүүл мэндийн клиник

Водяной оршин суугчид орчны эрүүл ахуйн шударга ёсны төлөө тэмцэж байна. Үүний зэрэгцээгээр тэд аюул гамшгийг эмчлэхийн төлөө ажиллаж байгаа юм. Ослоос амьд үлдсэн хүмүүс болон бусад сайн дурынхан хамтарч нийт оршин суугчдынхаа эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр эмчлэх Самба Хавна клиник гэх эмнэлгийг байгуулжээ. Санскрит, Хинди хэлээр бол Самба Хавна гэдэг нь боломж гэсэн үг юм. Самба Хавна клиник нь орчны эрүүл мэндийн загвар эмнэлэг юм. Энэ эмнэлэг нь аюулгүй бөгөөд тогтвортой ажиллагааг хангах зорилгоор бүтээгджээ. Жишээлбэл:

- Эмнэлгийг цэвэрлэхдээ, зөвхөн халуун ус саван хэрэглэх бөгөөд хортой

химийн цэвэрлэх бодисыг хэрэглэхгүйгээр зохион байгуулжээ.

- Эмнэлгийн ажилтнууд хашаандаа эмийн ургамал тарьж эхэлжээ. Хашаанд байгаа цэцэрлэгт хүрээлэнд химийн бордоо хэрэглэдэггүй байна. Эмнэлэгт эмчлүүлж байгаа хүмүүс эмнэлгийн цэцэрлэгт хүрээлэнгээс өөрсдийн эмчилгээнд хэрэглэх ургамал, навчийг түүдэг байна.
- Эмнэлгийн шинэ барилгыг барихдаа зөвхөн химийн хоргүй барилгын материалыг ашиглажээ. Барилга барихдаа орон нутгийн материалыг ашиглаж, байгалийн гэрлээр гэрэлтүүлгийг хангаж, агааржуулалтыг байгалийн агаарын урсгалаар хийхээр зохион байгуулжээ.
- Борооны улиралд дээрвээс гоожсон борооны усыг цуглуулах шугам хоолой татаж, цуглуулсан борооны ус нь газар доогуур байгаа усанд төвлөрөхөөр байгуулсан байна. Газар доор хадгалагдсан борооны усыг хуурай улиралд эргүүлэн ашиглаж, усны эх үүсвэрээ хангаж байна.
- Угаалга хийсний дараа бохир усыг тусдаа байрлаж буй цөөрөм рүү турба хоолойгоор хүргүүлэх бөгөөд тэрхүү усыг шүүж цэцэрлэгт хүрээлэнг услахад ашиглана.
- Байшингийн цахилгааныг нарны ялтас зайнаас гаргаж байгаа бөгөөд нарны зай нь өчүүхэн бага бохирдлыг үүсгэж байна.



Самба Хавна эмнэлэг нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийн тулд зөвхөн өвчтэй хүмүүсийг эмчлэх төдийгүй бас эрүүл хүмүүсийг өвчлөхөөс хамгаалах жишээ болж байна. Химийн хортой бодисын хэрэглээг багасгах тэдний жишээ нь сургууль, бизнесийн байгууллага, засгийн газрын байрнууд, айлын гэр оронд хэрэглэх үлгэр дуурайл болж байна. Бид хэрэглээгээ ийнхүү багасгаж болох боловч химийн хорт бодисыг үйлдвэрлэсэн хэвээр байх юм бол хорт бодисын аюул бүрэн арилахгүй./ Самба Хавна эмнэлгийн талаар 351-р хуудаснаас дэлгэрэнгүй үзнэ үү/

Өөрчлөлтийн төлөө ажиллах нь

Удаан хугацааны эрүүл орчин, эрүүл аюулгүй амьдралын төлөөх хийсэн Вопалын оршин суугчдын тэмцэл нь орчны аюулгүй байдлын талаарх хүний эрх, шударга ёсны төлөөх тэмцэлд дэлхий нийтийг зоригжуулж уриалсан юм. Химийн бодисын аюулыг багасгахын төлөө зохион байгуулалттай тэмцэлд дараах зарчмууд хамгийн их ашигтай болох нь батлагдлаа:

- **Өдөр тутмын амьдралдаа хортой зүйл хэрэглэхээс зайлсхий.** Гэр, байгууллага, ажлын байраа цэвэрлэх үедээ хоргүй химийн бодисыг хэрэглэж байна. /378-380-р хуудсыг үз/ Өөрийн цэцэрлэгт хүрээлэн, тариан талбайдаа химийн бордоо бүү хэрэглэ. Химийн бордоо хэрэглэсэн хоол хүнсийг бүү ид. Ногоо жимсийг идэхийн өмнө сайтар угаа./14-р бүлгийг үз/ Бидний орон нутаг болон оршин суугаа газруудад химийн хорт бодис тархах бололцоотой учраас засгийн газрууддаа шахалт дарамт үзүүлж химийн хортой үйлдвэрүүдийг орон сууцны хорооллуудын ойролцоо байлгахыг зогсоо хэмээн шаардах ёстой.

- **Бохирдлоос урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ**

ав. Химийн хорт бодисын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд өлсгөлөн зарлах, суулт зарлах, явган марш хийх, театрын жүжиг тоглох, хэвлэл мэдээлэл, интернет болон бусад харилцааны хэлбэрээр сурталчилгаа хийх буюу олон үйл ажиллагааг хэрэглэ. Хэрэв үйлдвэр хорт хий, хорт бодис ялгаруулж байвал тэнд ажиллаж буй ажилчдад хоргүй өөр ямар амьжиргааны арга байгааг эрж хайж ол. Яагаад гэвэл, хүн бүхэнд ажил орлого хэрэгтэй.

- **Компаниудад цэвэрлэгээ хийхийг тулган шаард.**

Энэ шаардлагын хүчээр амжилтад хүрэхэд хэцүү ч компаниудад хорт хаягдлаа цэвэрлэх шаардлага байнга тавих нь эрүүл орчинд амьдрахын салшгүй хэсэг юм. Хэдийгээр компаниуд болон корпорациуд өөрсдөө зөвшөөрдөггүй ч гэсэн орчны байгалийг хордуулсныхаа хариуцлагыг компаниуд өөрсдөө хүлээх ёстой гэдэгтэй хүмүүс санал нэг байдаг.

- **Засгийн газруудад аюулгүйн стандартаа сайжруулах шахалт үзүүлж шаардлага тавь.** Харамсалтай

нь, ихэнх засгийн газрууд корпорациудын ашгийг хүнээ хамгаалахаас илүү авч үздэг. Ингэснээр орчны эрүүл ахуйн асуудлаар шударга бус үзэгдэл газар авч, компаниуд хариуцлага хүлээхгүйгээр аюултай үйлдлээ үргэлжлүүлдэг. Засгийн газрууд хэнийг хамгаалах талаарх бодлоо өөрчилж хүмүүсээ, ялангуяа хамгийн их тусламж шаардсан хүмүүсээ эхний ээлжинд хамгаалах үүргээ ухамсарлах ёстой.

- **Үйлдвэрүүдийн ажлаа явуулах аргыг нь өөрчлүүлэх хэрэгтэй.** Вопал хотод ажиллаж байсан “Юнион карбид” хэмээх үйлдвэр нь тариалангийн хортон шавжийг устгах хор хийдэг байжээ. Гэтэл тариалангийн хортон шавжийг устгахын тулд заавал химийн бодис шаардлагагүй байдаг. Байгаль орчинд хоргүй тогтвортой аргаар хортон шавжийг хязгаарлаж болдог олон арга байдаг байна. Ийм байсаар байтал яагаад хүмүүсийг үйлдвэрийн хороор хордохыг нь зөвшөөрч байгаа хэрнээ үйлдвэрийн талаар шийдвэр гаргахад оролцуулахгүй байна вэ?

Хэрэв засгийн газар биднийг үр хүүхэд, гэр бүл шигээ хайрлаж чаддаг байсан бол бидний амьдрах орчин эрүүл аюулгүй байх байсан юм.




Боломжийн эрсдэл гэв үү? Хэний хувьд?

Үйлдвэрийн газрууд болон засгийн газрууд байгаль орчны хохирлын эрсдэлийг (Вопалд тохиолдсон шиг гамшгийг хүртэл) хөгжлийн төлөөс хэмээн нэрлэж, хүлээн зөвшөөрч байдаг. Энэ бол бидний дунд байгаа хамгийн ядуу, хамгийн эмзэг хэсэг нь бизнесийн ашгийн төлөө хохирно гэсэн үг юм. Олонхи хүмүүсийн хувьд энэ бол хүлээн зөвшөөрөх аргагүй зүйл юм. Ашиг хөөцөлдөх нь хүний эрүүл байх эрхийг зөрчих, орчин тойрны эрүүл байдлыг сүйтгэхэд гол хүчин зүйл болдог бөгөөд энэ их хохирлыг ашиг олсноор зөвтгөж боломгүй юм. Хэрэв “Юнион карбид” компани буюу Энэтхэгийн засгийн газар болгоомжлох зарчмыг барьж чадсан бол Вопалын хорт хийн аюул учрахгүй байж болох байсан.


Болгоомжлох зарчмыг шаардах нь

Аюулгүй байдлын арга хэмжээ учрах хохирлыг багасгаж чадна. Аюулгүй байдлын арга хэмжээ авлаа ч үйлдвэрийн газруудад эрсдэл үргэлж байсаар байдаг. Хэрэв эрсдэлээс зайлж чадахгүй бол тэр эрсдэлийг ядахдаа тэнцүү хуваах хэрэгтэй. Харин эрсдэлийг зөвхөн ядуу, эмзэг хүн амд дангаар ноогдуулж болохгүй. Урт хугацааны туршид аюулгүй байхын тулд үйлдвэрийн газрууд өндөр ашгийн төлөө хөөцөлдөхөөс илүү аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны үнэт зүйлийг дагах ёстой. Үүнд хүрэхийн тулд үйлдвэрийн газар, компаниудыг аюулгүй бөгөөд шударга аргаар ажиллахыг бид шаардах ёстой ба засгийн газрууд тухайн үйлдвэрүүдэд хууль хэрэгжиж байгаа, хүний болон орчны эрүүл мэнд хамгаалагдаж байгаа эсхийг шалгаж дүгнэж байх ёстой. Байгаль орчны шударга ёсыг бүх нийтэд тогтоох нэг арга нь удирдагч нар болон шийдвэр гаргагч хүмүүс болгоомжлох зарчмыг удирдлага болгох явдал юм.



Утаатай үйлдвэр...

**Болгоомжлол,
сэрэмжлүүлгийг шаард!**



утаатай буу зэвсэг болон хувирч чадна.